

2022 оны 12 дугаар 13-ны өдөр

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД

Шинжээч сонгон шалгаруулах мэдүүлэг хүлээн авах урилга

Үндэсний аудитын газар нь “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн”-сэдэвт гүйцэтгэл-нийцлийн аудитын хүрээнд “Тус чиглэлийн төмөр замын суурь бүтцийн зураг төсөл, төсөвт өртөг болон ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, норм, дүрэм, стандарт шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, дүгнэлт гаргах” шинжээчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан хамтран ажиллах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээний хүрээнд холбогдох ажлын даалгаварт тусгагдсан доорхи ажилбаруудыг гүйцэтгэж, аудитын талбарын болон тайлагналын үе шатны үйл ажиллагаанд шаардлагатай, мэргэжлийн, шинжлэх ухааны үндэслэлтэй хараат бус санал, дүгнэлт гарган ажиллах бөгөөд, мэргэжлийн зөвлөх үйлчилгээг 3 хүртэл сарын хугацаанд гүйцэтгэн, тайлан дүгнэлтийг аудитын багт хүлээлгэн өгнө. Үүнд:

1. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн ТЭЗҮ болон зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм ба дүрмийн шаардлагыг хангаж, төлөвлөлт, судалгаанд үндэслэсэн эсэхэд дүгнэлт гаргах
2. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын ажлын зураг төсөл, ТЭЗҮ-г холбогдох хууль тогтоомж, стандарт, норм ба дүрэм, жишиг үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиож, магадлалаар баталгаажуулсан эсэхэд дүгнэлт гаргах
3. Тус чиглэлийн төмөр замын суурь бүтцийн ажлын гүйцэтгэл нь ТЭЗҮ, зураг төсөл, норм ба дүрэм, стандартын дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргах
4. Мөн төмөр замын суурь бүтцийн ажлын гүйцэтгэлийн үе шатны ажилд хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байдал, өгсөн зааварчилгаа, түүний хэрэгжүүлж ажилласан байдлыг нягтлан шалгаж, дүгнэлт гаргах
5. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулах техникийн болон улсын комисс ажилласан бол тэдгээрээс өгсөн үүрэг даалгавар хэрэгжсэн эсэхэд дүгнэлт гаргах;
6. Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад орц, материалын тоо хэмжээ, нэр төрөл, чанар, агууламж зэргийг баталж, хянаж баталсан төсөв болон бодит гүйцэтгэл хооронд зөрүү илэрсэн тохиолдолд гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх нөлөөллийг тогтоож, төсөвт гарсан хэмнэлт, хэтрэлтийг тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргах:

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх, шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт ирүүлэхээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр
/2019, 2020, 2021 он/;
- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2020, 2021
оны жилийн эцсийн/.

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;

- Багийн гишүүдийн хамтран ажиллах гэрээ ирүүлэх /нотариатжуулсан/:

Шинжээчид тавигдах шаардлага:

Шинжээч нь Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн ТЭЗҮ, зураг төсөл, төсөв, магадлал, үе шатны ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргах эрх бүхий, тус төслийн үр ашиг, эдийн засгийн үр өгөөжийг тооцох, үнэлэх талаар мэргэшсэн /энэ чиглэлээр дүгнэлт гаргаж байсан бол давуу тал болно/, техникийн үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага, туршлагатай иргэн, хуулийн этгээд байх ба шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөх ба дараах шаардлагыг хангахуйц байна. Үүнд:

- Иргэн, хуулийн этгээд /түншлэлээр оролцож болно/ нь зөвлөх үйлчилгээг багаар үзүүлнэ. /5 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх/
- Багийн ахлагч нь төмөр замын чиглэлээр мэргэжилтэй болон холбогдох бусад чиглэлээр мэргэшсэн байх.
- Багийн ахлагч болон гишүүд нь барилга, байгууламжийн төсөв тооцоолох чадвартай, мэргэшсэн төсөвчин байвал давуу тал болно.
- Судалгаа шинжилгээний болон шинжээчийн ажлын туршлагатай байх.

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 15 цаг 00 минутаас өмнө www.audit.mn цахим хаягаас болон УАГ-ын Захиргаа, хууль, эрх зүйн газрын худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюушаас /ажлын утас: 51-261745, гар утас: 88051068/ авч болох бөгөөд мэдүүлгээ файл хэлбэрээр info@audit.gov.mn, tsend-ayushn@audit.gov.mn цахим шуудангаар **2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 15 цаг 30 минутаас өмнө ирүүлнэ үү.**

Захиалагчийн хаяг: Үндэсний аудитын газар-15160. Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр.